



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Тарифт өөрчлөлт оруулах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо болон “Ди би эм лизинг” ХХК-ийн хооронд байгуулсан 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ХАГ-22/01 дугаартай “Төсөл хэрэгжүүлэх хамтран ажиллах гэрээ”, Эрчим хүчний зохицуулах хороо, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК, “Улаанбаатарын дулааны сүлжээ” ТӨХК, “Амгалан дулааны станц” ТӨХК болон “Ди би эм лизинг” ХХК-ийн хооронд байгуулсан 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн СТГ-22/01 дугаартай “Санхүүгийн түрээсийн гэрээ”, Эрчим хүчний яамны 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн в/699 дугаар албан бичиг, “Амгалан дулааны станц” ТӨХК-аас ирүүлсэн саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн “Тариф батлах тухай” 444 дүгээр тогтоолын хавсралтын 1 дэх хэсгийн 2 дугаар мөрний “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн “Улаанбаатарын дулааны сүлжээ” ТӨХК-д худалдах дулааны “энергийн тариф 23,041.0 төг/Гкал” гэснийг “энергийн тариф 25,429.5 төг/Гкал буюу 6,074.0 төгрөг/ГЖ”, 2 дахь хэсгийн 2 дугаар мөрний “чадлын тариф (НӨАТ-гүй)-ыг 3,083,918.2 мян.төг/сар” гэснийг “чадлын тариф (НӨАТ-гүй)-ыг 4,357,919.0 мян.төг/сар” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Өөрчлөлт оруулсан тарифыг 2023 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Амгалан дулааны станц” ТӨХК (М.Мөнхөө), “Улаанбаатарын дулааны сүлжээ” ТӨХК (Г.Баярсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

4. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн “Тариф батлах тухай” 108 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ



Э.ТҮВШИНЧУЛУУН

П.ТОВУУДОРЖ

Л.ДАШМЯГМАРЖАВ

Ц.НОРОВЖАМЦ

Д.ЦОГОО

• 230000671